



**УЛСЫН НЭГДҮГЭЭР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

14210 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
С.Зоригийн гудамж-2, Утас: +976-77111027

И-мэйл: info@fchm.edu.mn

2025. 08. 21 № 1/1238
танай 2025. 08. 19 -ны № 6/3975 -т

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ
НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
БОДЛОГЫН ГАЗАРТ**

Тайлан хүргүүлэх тухай

2025 оны 08 дугаар сарын 19-ний өдрийн 6/3975 албан тоот Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолоор батлагдсан “Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн биелэлтийг 2017-2025 оны байдлаар гарган хүргүүлж байна.

Хавсралт 10 хуудастай.

**ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ**




Л.БЯМБАСҮРЭН

142251904

УЛСЫН НЭГДҮГЭЭР ТӨВ ЭМНЭЛГИЙН "АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ" ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

/2017-2025 оны байдлаар/

№	Төлөв лөгөө ний залт	Үйл ажиллагаа	Бүтээгдэх үүн	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа	Хэрэгжилт
1	5.5.1.	Агаарын бохирдол болон бусад нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн эрсдэлийн үнэлгээг эрүүл мэндийн байгууллагууда д хийх	Эрүүл мэндийн сайдын тушаал	Агаарын бохирдол болон зарим халдварт өвчний тархалт хариу арга хэмжээний бэлэн байдалд эрсдэлийн үнэлгээ хийж бэлэн байдлыг хангаж, хариу арга хэмжээг зохион байгуулсан байна.	ЭМЯ	Эрүүл мэндийн байгууллага уд	2017- 2025	2022 оны 01 сарын 21-ний өдөр коронавирус цар тахлын үеэр УНТЭ-ийн зорилтот бүлгийн (галлагаатай байшин, гэрт амьдардаг) ажилтнуудад зориулан угаарийн хийн хордлогоос урьдчилан сэргийлэх, угаартах эрсдэлээс хамгаалах зорилгоор НЭМҮТ-тэй хамтран цахим сургалтыг зохион байгуулан ажилласан. Уг сургалтаар НЭМҮТ-ийн Тархвар зүй, шуурхай удирдлагын албаны дарга, тархвар зүй удирдлагын албаны хими, химийн хор хариуцсан мэргэжилтэн, УНТЭ-ийн ЯТТ-ийн эрхлэгч нар • "Угаарын хийн хордлогын тохиолдол, урьдчилан сэргийлэх арга хэмжээ" • "Угаарын хий гэж юу вэ? Түүний орц найрлага, Угаарын хийн мэдрэгч суурилуулах, ажиллуулах дараалал" • "Угаарын хийн хордлогоор хордсон үед үзүүлэх анхны тусламж, эмчилгээ үйлчилгээ" сэдвүүдээр зохион байгуулсан. Уг сургалтад нийтдээ 60 гаруй ажилтан хамрагдсан.




11	5.6.3	Дам тамхидалтын хор уршгийг сурталчлах, мэдээлэл сурталчилгаан ы кампанит ажлыг зохион байгуулах	Мэдээлэл сургалт сурталчил гааны стратегит Сурталчи лгааны тайлан	Дам тамхидалтын хор уршгийн талаар олон нийтэд сургалт ухуулга хийж, сурталчилгаан ы материалыг түгээсэн байна.	ЭМЯ	ЭМЯ-ны харьяа байгууллага уд	2017- 2025	2017 он	/Зураг 1. Сургалтын явцаас/ Эрүүл мэндийн сайдын 2017 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/412 тоот "Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" тушаалаар батлагдсан "ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ"-ний дагуу УНТЭ-т хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллах төлөвлөгөөг 7 чиглэлээр, 13 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр боловсруулан гаргасан. Мөн А/412 дугаар тушаалаар батлагдсан үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний үйл ажиллагааны чиглэл 4-ийн 3.4.3 дэх "Дам тамхидалтын хор уршгийн талаар иргэдэд зориулсан зөвлөмж, сургалт, сурталчилгааны материал боловсруулан түгээх" заалтын дагуу: • УНТЭ-ийн уушгины эмгэг судлалын тасгаас нийт хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгч болон амбулаториор үйлчлүүлж буй 250 гаруй үйлчлүүлэгч нарт тамхины хор хөнөөл түүнээс үүдэх өвчлөлийн талаарх эрүүл мэндийн боловсрол олгох сургалт явуулж, гарын авлага материалыг тараасан бөгөөд 70 орчим эмчлүүлэгч тамхинаас гарсан үр дүнтэй байна. • УНТЭ-ийн УЭСТ-ийн эмч нар, сувилахуйн баг,
----	-------	--	--	--	-----	---------------------------------------	---------------	---------	--

											нийгмийн эрүүл мэндийн багийн гишүүд хамтран 2017 оны 05 дугаар сарын 31-нд "Дэлхийн тамхигүй өдөр"-ийг эмнэлгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлж нийт 150 гаруй иргэд үйлчлүүлэгч оролцсон. - УЭСТ-ийн эмч нар, сувилахуйн баг хамтран тасагт 14 хоногт 1 удаа томуу, томуу тест өвчнөөс урьдчилан сэргийлэх, амьсгалын замын өвчний үеийн дасгал, тамхины хор хөнөөл, тамхинаас гарах сургалтыг тасралтгүй явуулж хэвшсэн. - Мөн НЭМҮТ-тэй хамтран хэвтэн эмчлүүлэгч нарт зориулсан тамхины хор хөнөөлийн талаар гарын авлага, видео хичээл бэлтгэн танилцуулж байна.		2018 он Эрүүл мэндийн байгууллагыг түшиглэн ард иргэдийг тамхинаас гарах хүсэл төрүүлэх, хортзуршлыг хаях зан үйлийг төлөвшүүлэх ажлын хүрээнд УНТЭ-т хэвтэн эмчлүүлж буй үйлчлүүлэгч болон амбулатороор үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдэд дам тамхидалтын хор уршгаас сэргийлэх үйл ажиллагааг жил бүр тогтмол явуулж хэвшээд байна. 2018 оны "Тамхитай тэмцэх дэлхийн өдөр"-ийн хүрээнд уушгины тасгийн эмч нар, сувилахуйн баг, нийгмийн эрүүл мэндийн багийн гишүүд хамтран 5 дэх жилдээ тодорхой уриан дор амбулаториор үйлчлүүлэгч олон нийт болон УЭСТ-т
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	---	--

/Зураг 2. Үзлэг, сургалтын явц/


хэвтэн эмчлүүлэгчидтэй хамт тэмдэглэн өнгөрүүлсэн. Тус өдөрлөгийн үеэр амбулаториор үйлчлүүлж буй 350 гаруй үйлчлүүлэгчид нарт тамхины хор хөнөөл, дам тамхидалтаас үүдэх өвчний талаар сургалт хийж, гарын авлага, тараах материал тараахаас гадна МонголHD телевизийн "Өглөө" хөтөлбөрт оролцож олон нийтэд "Тамхи"-ны хор хөнөөлийг талаар мэдээлэл түгээн ажилласан. Мөн УЭСТ-ийн эмч нар, Сувилахуйн баг хамтран хэвтэн эмчлүүлэх тасгуудад сард 1 удаа томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, амьсгалын замын өвчний үеийн дасгал, тамхины хор хөнөөл, тамхинаас гарсны дараах биед гарах эерэг нөлөөнүүдийн талаарх сургалтыг тасралтгүй явуулж хэвшсэн. Тус сургалтад жилийн хугацаанд нийт 230 гаруй үйлчлүүлэгч хамрагдсан.



/Зураг 3.Үзлэг, Ярилцлагын явцаас/

2019 он


2019.05.31-ны Тамхины эсрэг дэлхийн өдрийг "Тамхины хор уршиг, тамхи таталтыг бууруулах, урьдчилан сэргийлэх" сэдвээр тэмдэглэн өнгөрүүлж нийт 120 орчим иргэд үйлчлүүлэгчид хамрагдан тамхи татахын хор уршгийн талаар боловсрол олгох, мэдээлэл түгээх арга хэмжээг зохион байгуулан ажилласан.



Зураг 4. Өдөрлөгийн явцаас/


2020 OH

Эмнэлэг эрүүл бүс - Тамхигүй орчин ажлын хүрээнд
эмнэлгийн гадаад дотоод орчинд тамхи татахыг
хориглосон постер байршуулсан.



/Зураг 5.Мэдээлэл байршуулсан явцаас/

“Тамхины эсрэг дэлхийн өдөр”-ийг тохиолдуулан тамхины хор уршиг, агуулагдах хорт бодис болон хэрхэн тамхинаас гарах талаар эрүүл мэндийн эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор видео хичээл бэлтгэн эмнэлгийн гадаад дотоод сайтад байрлуулан ажилласан



/Зураг 6. Нөлөөллийн ажлын явцаас /

2021 OH

Уушгины архаг бөглөрөлт өвчинтэй тэмцэх дэлхийн өдрийг “ЭРҮҮЛ УУШГИ - ҮНЭЭС ӨӨР ЭРХЭМ ЗҮЙЛ ҮГҮЙ” уриатайгаар 2021.11.19-ны өдөр амбулаториор үйлчлүүлж буй үйлчлүүлэгчдийн дунд тэмдэглэн өнгөрүүлээ. Уг өдөрлөгөөр УХТ-ийн эмч, сувилагч, резидентэд суралцагчид амбулаторийн 2-р давхраар үйлчлүүлж буй олон нийт болон эмнэлгийн эмч, мэргэжилтнүүдэд уушгины архаг бөглөрөлт өвчний талаар мэдээлэл олгох танилцуулга сургалт хийж, дам тамхидалт болон электрон тамхины хор хөнөөлийн талаарх мэдээлэл бүхий мэдээллийн хуудас 150 ширхэгийг тарааж өгсөн. Мөн амбулаториор үйлчлүүлж буй олон нийтэд зориулж тамхины хэрэглээ хор хөнөөлийн талаарх видеог бэлтгэн бүх дэлгэцүүдэд байршуулсан




/Зураг 7. Өдөрлөгийн явцаас/

2023 он



МУ-ын Ерөнхийлөгчийн 43-р зарлиг “Эрүүл Монгол

хүн" хөтөлбөр, ЭМС-ын А780 тоот тушаал "Эрүүл идэвхтэй амьдрал" арга хэмжээ, А/816 дугаар тушаал "Харшлаас сэргийлэх" арга хэмжээ, Ерөнхий захирлын 2023 оны А95 тоот тушаалын дагуу "Эмнэлэг тамхигүй орчин" аяныг өрнүүлж дам тамхидалтаас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд "Тамхины хяналтын хууль"-ийн дагуу зөвшөөрөгдсөн тамхины цэгийг байгуулж, цэгээс бусад газарт утаат тамхи татахыг хориглосон тэмдэглэгээг байршуулж ажилласан.



/Зураг 8. Эмнэлэг-Тамхигүй орчин нөлөөллийн ажлын явцаас/

УНТЭ-ийн төв, тасаг, нэгжүүдийн дунд "Эрүүл уушги эрүүл эмнэлэг" аяны хүрээнд бусдыг уриалсан, сурталчлан таниулах аян өрнүүлэн УХТ, ЧХХМЗТ-ийн эмч мэргэжилтнүүдтэй хамтран "Тамхины хор нөлөө" сэдэвт зөвлөгөө мэдээлэл олгох нөлөөллийн контент видеог цахим орчинд байршуулан ажилласан.

												Сүхбаатарын яаман Хүнд 300-400 орчим хүн хамран дайвар хэргийн үндсэн үйлчилгээг үйлдэж байгаа бөгөөд үүнийг 9.1.6-д заасны дагуу байр... 	Сүхбаатарын яаман Хүнд 300-400 орчим хүн хамран дайвар хэргийн үндсэн үйлчилгээг үйлдэж байгаа бөгөөд үүнийг 9.1.6-д заасны дагуу байр... 	Сүхбаатарын яаман Хүнд 300-400 орчим хүн хамран дайвар хэргийн үндсэн үйлчилгээг үйлдэж байгаа бөгөөд үүнийг 9.1.6-д заасны дагуу байр... 	Сүхбаатарын яаман Хүнд 300-400 орчим хүн хамран дайвар хэргийн үндсэн үйлчилгээг үйлдэж байгаа бөгөөд үүнийг 9.1.6-д заасны дагуу байр... 	Сүхбаатарын яаман Хүнд 300-400 орчим хүн хамран дайвар хэргийн үндсэн үйлчилгээг үйлдэж байгаа бөгөөд үүнийг 9.1.6-д заасны дагуу байр... 	Сүхбаатарын яаман Хүнд 300-400 орчим хүн хамран дайвар хэргийн үндсэн үйлчилгээг үйлдэж байгаа бөгөөд үүнийг 9.1.6-д заасны дагуу байр... 	Сүхбаатарын яаман Хүнд 300-400 орчим хүн хамран дайвар хэргийн үндсэн үйлчилгээг үйлдэж байгаа бөгөөд үүнийг 9.1.6-д заасны дагуу байр... 
												Сүхбаатарын яаман Хүнд 300-400 орчим хүн хамран дайвар хэргийн үндсэн үйлчилгээг үйлдэж байгаа бөгөөд үүнийг 9.1.6-д заасны дагуу байр... 	Сүхбаатарын яаман Хүнд 300-400 орчим хүн хамран дайвар хэргийн үндсэн үйлчилгээг үйлдэж байгаа бөгөөд үүнийг 9.1.6-д заасны дагуу байр... 	Сүхбаатарын яаман Хүнд 300-400 орчим хүн хамран дайвар хэргийн үндсэн үйлчилгээг үйлдэж байгаа бөгөөд үүнийг 9.1.6-д заасны дагуу байр... 	Сүхбаатарын яаман Хүнд 300-400 орчим хүн хамран дайвар хэргийн үндсэн үйлчилгээг үйлдэж байгаа бөгөөд үүнийг 9.1.6-д заасны дагуу байр... 	Сүхбаатарын яаман Хүнд 300-400 орчим хүн хамран дайвар хэргийн үндсэн үйлчилгээг үйлдэж байгаа бөгөөд үүнийг 9.1.6-д заасны дагуу байр... 	Сүхбаатарын яаман Хүнд 300-400 орчим хүн хамран дайвар хэргийн үндсэн үйлчилгээг үйлдэж байгаа бөгөөд үүнийг 9.1.6-д заасны дагуу байр... 	Сүхбаатарын яаман Хүнд 300-400 орчим хүн хамран дайвар хэргийн үндсэн үйлчилгээг үйлдэж байгаа бөгөөд үүнийг 9.1.6-д заасны дагуу байр... 


/Зураг 9.Нөлөөллийн ажлын явцаас/

2024 он

Улсын Нэгдүгээр Төв Эмнэлгийн НЭМАлба нь тамхины хяналтын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, эмнэлгийн орчин дахь эрүүл аюулгүй ажлын байр бүрдүүлэх, дам тамхидалтад өртөхөөс урьдчилан сэргийлэх, ажлын хүрээнд “Эмнэлэг тамхигүй ногоон бүс” ухуулга нөлөөллийн 2023 оноос эхлүүлсэн бөгөөд уг аяны хүрээнд тамхины хяналтын тухай хуулийн дагуу эмнэлгийн гадна талбайд зөвшөөрөгдсөн бүсэд стандарт бүхий тамхины цэгийг байгуулсан бөгөөд хуулийн 9.1.6, 9.1.8-д заасны дагуу эмнэлгийн гадаад болон дотоод орчинд утаат тамхи татахыг хориглож, эмнэлгийн ойр орчмын байгууллагуудад зөвшөөрөгдсөн цэгээс бусад цэгт тамхи татахгүй байх, эмнэлэг ногоон бүс чиглэлээр хамтран ажиллах санамж бичиг илгээн ажилласан. 2024 онд эмнэлгийн утаат тамхи татдаг хэсгүүдэд хориглох тэмдэг тэмдэглэгээг байршуулсан бөгөөд электрон болон утаат тамхи татахгүй байхыг цахим орчинд өрнүүлэн ажиллаж байна.

УНТЭ-ийн Эцэг эхийн зөвлөлөөс 2024.04.16-ны өдөр

“Аав ээжийнхээ ажлын нэг өдөртэй танилцах” өдөрлөг зохион байгуулж ЕБС-ын 12-р ангийн 15 сурагчдад “Электрон тамхины хор хөнөөл” сэдвээр зөвлөгөө мэдээлэл олгосон.



/Зураг 10. Сургалтын явцаас/

2025 OH

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгыг 2025.05.05-ний өдөр ЭМЯ-н дээр тус хуулийн төслийн ажлын хэсгийн ахлагч УИХ-ын гишүүн О.Номинчимэг танилцуулга хийсэн бөгөөд тулгамдсан асуудлаа хамтдаа тодорхойлон, хүүхэд залуусыг хорт зуршлаас салгах боломжуудын талаар санал солилцох арга хэмжээнд УНТЭ-ийн төлөөлөл оролцож саналаа өгөн оролцож ажилласан.




/Зураг 11. Сургалтын явцаас/

ДЭМБ-аас жил бүрийн 05 дугаар сарын 30-ны өдрийг “Дэлхийн тамхигүй өдөр” болгон тэмдэглэдэг бөгөөд “Тамхигүй хойч үеийн төлөө тамхины үнэнийг илчилье!” уриан дор 11-р сургуулийн есдүгээр ангийн 4 бүлгийн 150 сурагчдад “Тамхины хор уршиг” сэдвээр

[illegible]

сургалтыг танхимаар орж тамхи, электрон тамхины хор уршгийг таниулах сургалтыг зохион байгуулан ажилласан. МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан “Эрүүл Монгол хүн хөдөлгөөн” үндэсний хөдөлгөөний хүрээнд ЭМЯ, НЭМҮТ хамтран зохион байгуулсан “Тамхигүй хойч үеийн төлөө тамхины үнэнийг илчилъе!” арга хэмжээнд УНТЭ-ийн ажилчид оролцож тамхигүй хойч үеийн төлөөх Монгол залуусын Тунхаглалд нэгдсэн.



Зураг 12. Сургалтын явцаас /

Хянасан:

Г.Алтанцоо, Нийгмийн эрүүл мэндийн албаны дарга

Боловсруулсан:

Д.Гандулам, Нийгмийн эрүүл мэндийн албаны мэргэжилтэн